

**“Эрдэнэс-Тавантолгой ХК”**

Огноо: .....

**УУРХАЙН АЮУЛГҮЙН ТУУЗ, КОНУС, НААЛТ БОЛОН  
БУСАД ТЭМДЭГЛЭГЭЭ НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** Уурхайн аюулгүйн тууз, конус, наалт болон бусад тэмдэглэгээ нийлүүлэгчийг сонгох

**Харьцуулалт/  
гэрээний дугаар:** ЭТТ/201901250

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

**“Эрдэнэс-Тавантолгой” ХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Аюулгүйн тууз, наалт бусад тэмдэглэгээ”** нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭТТ/201901250 дугаартай харьцуулалтын тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2019 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 10 цаг 40 минутад “Эрдэнэс Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхрын хурлын өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,  
Финанс төв 5 давхар, 503 тоот, Улаанбаатар-15160,  
Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн хэлтэс  
Утас: 75055555-504**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |      |  |
|---|------|--|
| <b>1.</b> Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2.</b> Тендер ирүүлэх, тендерийн нээлт               | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.   |
|   | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3.</b> Тендерийн иж бүрдэл                           | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| <b>4.</b> Тогтмол үнэ                                   | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5.</b> Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.  |
|   | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6.</b> Үнийн саналын хүчинтэй байх хугацаа           | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.  |
| <b>7.</b> Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх            | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.   |
|   | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.   |
|   | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.  |

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.



Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>2. Сүүлийн 2 жилийн 2017, 2018 онуудад ижил төстэй 2-оос доошгүй бараа нийлүүлсэн гэрээг нотариатаар баталгаажуулан ирүүлэх.</li> <li>3. Гэрээ дүгнэсэн акт эсвэл гэрээ байгуулсан газрын тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>4. Татварын газрын цахим тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар ирүүлэх/</li> <li>5. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар</li> <li>6. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлэх /тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр хугацаатай байна/</li> <li>7. Тендерт шалгарсан тохиолдолд санал болгосон бараа техникийн тодорхойлолтын дагуу бараа материал нийлүүлэх гэсэн албан бичиг ирүүлнэ үү.</li> </ol> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. /ҮГҮЙ/</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:          Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот-15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв</b>  <b>Утас: 70118585 (562), факс: 70118464</b>          Давхар болон өрөөний дугаар: <b>5 давхар 503 тоот</b>          Огноо: <b>2019 оны 06 дугаар сарын 25-ны өдөр</b>          Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:          Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот-15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8, Финанс төв</b>          Давхар болон өрөөний дугаар: <b>5 давхар 503 тоот</b>          Огноо: <b>2019 оны 06 дугаар сарын 25-ны өдөр</b>          Цаг: <b>10 цаг 40 минут</b></p>
ТӨӨЗ 6.2	<p><b>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</b></p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


1. Барааны тодорхойлолт:

№	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР / сэлбэг, барааны дугаар/	Хэмжих нэгж / Тоо хэмжээ		ЗОРИУЛАЛТ	ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ	Үлдэгдэл <i>/тоо ширхэг/</i>
1	Стикер наалт	ш	320	Дуут дохио ашиглах журмын дагуу Цагдаагийн байгууллагаас тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор онцгой байдлын дуудлага хүлээн авах утас автомашинуудад байрлуулах	Хавсралт №1-ээс харна уу. 	0
2	Стикер наалт	ш	384	“ЭТТ”ХК-ийн уурхайд нэвтрэх хөнгөн тэрэгнүүдэд байрлуулах <i>/LV 001 – ээс LV 048хүртэл/</i>	Хавсралт №2-оос харна уу. 	0
3	Стикер наалт	ш	256	ЭТТ”ХК-ийн уурхайд нэвтрэх, ажиллах үйлчилгээний тэрэгнүүдэд байрлуулах <i>/SV 001 – ээс SV 032/хүртэл</i>	Хавсралт №3-аас харна уу	0
4	Цацруулагчтай наадаг улаан тууз	ш	30	Шөнийн цагаар машины гэрэл ойлгож гэрэлтэх зорилгоор машины урд, ард, хажуу хэсэгт наана мөн PVC хоолойнд нааж замын хөмсөгүүд дээр байрлуулна.	Хавсралт№4-өөс харна уу. 50мм-ийн өргөнтэй, 90м-ийн урттай, талстлаг хээтэй, өнгө алаглаагүй, чанар сайтай байна. 	0
	Цацруулагчтай наадаг шар тууз	ш	30			0
	Цацруулагчтай наадаг цагаан тууз	ш	6			0
5	PVC хоолой	м	600	Уурхайн зам талбайн хамгаалалтын хөмсгөн дээр байрлуулна. 	2м-ийн урттай, 100мм-ийн диаметртэй, саарал өнгөтэй, гадаа нөхцөлд байрлуулах хоолой байна. 	0
6	Конус	ш	30	Яаралтай, түр хугацаанд засвар үйлчилгээ хийх, зам хааж нээх, хашлага	70 см-ийн өндөртэй, Конус хэлбэртэй,	0

				хаалт хамгаалатанд хэрэглэнэ.	цацруулагч наалттай, зөөврийн зориулалттай. Хүндрүүлэгчтэй 	
7	Анхааруулах тууз/ Danger/	ш	20	Яаралтай, түр хугацаанд засвар үйлчилгээ хийх, зам хааж нээх, хашлага хаалт хам хэрэглэнэ 	100 м урт, 10 см өргөнтэй, цагаан улаан өнгөтэй. Тусгаалах, түр хаалт хашилга хийж анхааруулахад хэрэглэнэ.	


### ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Стикерийн нийт хэмжээ: 71x12 см.
- Автомашины 2 талд наана. Жилд 2 удаа солигдоно.
- Үсэг болон тооны фонд нь "ARIAL" байна.
- Эхний хэсэг нь 22x12 см хэмжээтэй, суурь өнгө нь шар, түүн дотор байх ЭТТ гэсэн үг нь хар өнгөтэй бөгөөд үсэг нь 10x6 см хэмжээтэй, үсэг хоорондын зай нь 1 см.
- 2-р хэсэг нь 49x12 см-н хэмжээтэй, суурь өнгө нь хар, түүн дээр бичигдэх 80998099 гэсэн тоо нь шар өнгөтэй бөгөөд тоо нь 9x5 см-н хэмжээтэй, тоо хоорондын зай нь 1 см байна.
- Шөнийн цагаар гэрэлтдэг, гадаа нөхцөлд тэсвэртэй, цацруулагчтай фосфортой стикер наалт



### ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Автомашины 4 талд наана. нэг дугаар 4 ширхэг байж 1 багц болно. Жилд 2 удаа сольж наана. Паркын нэг дугаарыг 8 хувь байхаар хэвлэнэ.
- Паркын дугаарыг автомашины 2 талын хаалга, урд, ард талд байрлуулна.
- Хар дэвсгэр дээр шар өнгөөр “ARIAL” фонтоор “**BOLD**”-оор бичсэн байна. Хар дэвсгэрийн өнгөний код-250, шар үсэгний өнгөний код-503
- Паркын дугаарын дэвсгэр нь 220мм х 600 мм хэмжээтэй байна. Хар дэвсгэр доторх үсгийн өндөр нь 180мм, өргөн нь 560мм байна.
- Доторх үсэг болон тоо нь хар дэвсгэрийн хүрээнээс тус бүр 20мм-ийн зайтай байна.Үсэг, тооны нийт өргөнийг шахаж (Condensed) тааруулна.
- Шөнийн цагаар гэрэл ойлгодог, гадаа нөхцөлд тэсвэртэй сайн чанарын материалаар хийгдсэн байна.



### ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Автомашины 4 талд наана. Нэг дугаар 4 ширхэг байж 1 багц болно. Жилд 2 удаа сольж наана. Паркын дугаарыг автомашины 4-н талд байрлуулна.
- Паркын нэг дугаарыг 8 хувь байхаар хэвлэнэ.
- Хар дэвсгэр дээр шар өнгөөр “ARIAL” фонтоор “**BOLD**”-оор бичсэн байна. Хар дэвсгэрийн өнгөний код-250, шар үсэгний өнгөний код-503
- Паркын дугаарын дэвсгэр нь 220мм х 600 мм хэмжээтэй байна. Хар дэвсгэр доторх үсгийн өндөр нь 180мм, өргөн нь 560мм байна.
- Доторх үсэг болон тоо нь хар дэвсгэрийн хүрээнээс тус бүр 20мм-ийн зайтай байна.Үсэг, тооны нийт өргөнийг шахаж (Condensed) тааруулна.
- Шөнийн цагаар гэрэл ойлгодог, гадаа нөхцөлд тэсвэртэй сайн чанарын материалаар хийгдсэн байна.





Тав. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших  
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт  
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх  
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх  
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа  
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа *6 сар* байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах  
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр  
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь  
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах  
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах  
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх  
11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:  
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;  
Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.  
[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:  
Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн бараа нийлүүлэгдсэнээс хойш ажлын 5 хоногт төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **0.1%**  
Алдангийн нийт дүн: **10%**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

#### **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

---

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.